



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай 1,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,  
Цахим шуудан: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn),  
Цахим хуудас: [www.parliament.mn](http://www.parliament.mn)

2026.06.30 № 42

Хуулийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурал нь төрийн дотоод, гадаад бодлогын хүрээнд аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд үүнээс гадна тодорхой 18 төрлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Монгол Улсын Их Хурал улс орны дотоод, гадаад аливаа асуудлаар Үндсэн хуульд заасан уг бүрэн эрхээ чуулган, Байнгын, дэд хороо, ажлын хэсэг зэрэг хуралдааны хэлбэрээр хэрэгжүүлдэг бөгөөд олонхийн шийдвэрээр шийдвэрлэдэг.

Мөн чуулганы хуралдаануудыг хэрхэн зохион байгуулах асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар нарийвчлан зохион байгуулдаг бөгөөд уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.16 дахь хэсэгт “Тайлбар хийж, асуултад хариулж байгаа албан тушаалтан үнэн зөв мэдээлэл өгөх, асуултад товч, тодорхой хариулах үүрэгтэй бөгөөд гишүүн хариултыг хангалтгүй, эргэлзээтэй гэж үзвэл тухайн асуултын хариуг 2 хоногийн дотор бичгээр өгөхийг шаардах эрхтэй.” гэж түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.24 дэх хэсэгт “Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан болон бусад этгээд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй. Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо, Улсын Их Хурлын хяналтын сонсгол болон хяналт шалгалтын түр хорооны сонсголд оролцож байгаа этгээд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэг хүлээнэ.”, 21.26 дахь хэсэгт “Энэ хуулийн 21.24-т заасан холбогдох албан тушаалтан худал мэдээлэл өгсөн, танилцуулсан гэж үзвэл гишүүн хуралдаан даргалагчид санал гаргаснаар Тамгын газар, Үндэсний аудитын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндэсний статистикийн хороо, Төрийн албаны зөвлөл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл тухайн мэдээллийн үнэн зөв, бодит эсэхийг ажлын 5 өдрийн дотор хянаж, дүгнэлт гаргана.” гэж тус тус заасан байдаг.

Дээр дурдсан хуулийн тодорхой зохицуулалтуудын хэрэгжилтийг хангах, хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.24, 21.26 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.16 дахь хэсэгт холбогдох хуулийн хэрэгжилт, биелэлтийг хэрхэн зохион байгуулж байгаа тухай асуудлаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол

2026000122

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү асуулгыг тавьж байна.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ө.ШИЖИР

2026000122